

**“НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ
АВСТРИ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 3 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасныг үндэслэн 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улстай хөдөлмөр, нийгэм хамгааллын хүрээнд байгуулсан гэрээ, хэлэлцээрийг шинэчлэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат гадаад улсад хөдөлмөр эрхэлж буй иргэдийн бодит судалгаа мэдээлэл, нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр манай улсын иргэд олноор ажиллаж, амьдарч байгаа Япон Улстай гэрээ, хэлэлцээр байгуулах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн богино хугацаагаар гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах талаар, Монгол Улсад ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажилгүйдлийн түвшнийг бууруулах, ажиллах хүчний асуудалд дүн шинжилгээ хийж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат гадаад улсад ажиллаж, амьдарч буй иргэдийн гэр бүл, хүүхдийн сурч, боловсрох эрхийг хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн гадаад улс орнуудад ажиллах хүчээ алдахгүй байхад бодлогын түвшинд анхаарах шаардлагатай талаар үг хэлсэн болно.


“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**


Г.ТЭМҮҮЛЭН

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

~~НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН~~ ~~БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС ХООРОНДЫН~~ ~~ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ~~

1 дүгээр зүйл. Монгол Улс, ~~болон~~ Бүгд Найрамдах Австри Улс хооронд 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “Нийгмийн хамгааллын тухай ~~Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр~~”-ийг хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг